

## МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН НЭРЭМЖИТ ЭДИЙН ЗАСГИЙН МАГИСТРЫН ТЭТГЭЛЭГ

Монголбанкны эдийн засаг, санхүүгийн чиглэлийн судалгаа, сургалтыг дэмжих “Тинк банк” хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын их сургууль болон Монголбанк хамтын ажиллагааны 3 жилийн хугацаатай гэрээг 2020.09.23-нд байгуулсан<sup>1</sup>.

Энэхүү хөтөлбөр нь эдийн засаг, санхүүгийн чиглэлээр судалгааны магистрын түвшинд суралцаж буй оюутнуудын судалгааны чанарыг сайжруулах, Монголбанкны болон хөндлөнгийн судлаачдын хамтын ажиллагааг сайжруулах, судлаачдын бүтээлийг олон нийтэд түгээх, бодлого боловсруулахад оролцох оролцоог нь нэмэгдүүлэх зорилготой юм.

Уг хөтөлбөрийн хүрээнд эдийн засгийн судалгааны магистрт суралцагч шилдэг оюутнуудад Монголбанкны Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг олгох бөгөөд энэ нь тэднийг бүтэн цагаар суралцаж, судалгаа хийх нөхцөлөөр хангах зорилготой. Тэтгэлгийн сонгон шалгаруулалтыг Монголбанк, МУИС-ийн Эдийн засгийн тэнхим хамтран явуулна.

Уг тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсанаар гэсээ ёсоор

1. Сургалтын төлбөрөөс 100% чөлөөлөгдөнө.
2. Сар бүр амьжиргааны тэтгэлэг болгон 800 мянган төгрөг авна (1.5 жил хүртэл).
3. *Web of Science*-ийн индекстэй сэтгүүлд бүтээлээ нийтлүүлдэг судлаач багш нараар хичээл заалгаж, судалгааны ажилд нь оролцоно.

Тэтгэлэгт хамрагдахад тавигдах шаардлагууд:

- Магадлан итгэмжлэгдсэн дотоод, гададын их сургуулийн бакалаврын голч дүн 3.2, түүнээс дээш байх
- Сургалтын явцад тэнхимийн сургалт, судалгааны туслахаар ажиллах
- Тэнхимээс гадуур ажил эрхлэхгүй байх

Энэхүү хөтөлбөрийн өрсөлдөөнт шалгаруулалтад хамрагдахын тулд:

- МУИС-ийн Магистр, докторын хөтөлбөрийн элсэлтийн бүртгэлийн системд (<https://elselt.num.edu.mn>) 07.15-наас 09.10-ний өдрийн хооронд бүртгүүлнэ.
- Тоон сэтгэлгээн шалгалт өгнө (тоон мэдээллийг ойлгож, шинжилж, тайлбарлах ур чадвар, математикийн загвар ашиглаж асуудал шийдэх, арифматик, алгебр, геометр болон өгөгдөл шинжилгээний суурь ойлголтуудыг хэрэглэх чадварыг шалгана. Тоон сэтгэлгээнийх нь ур чадварт ач холбогдол өгнө. Түвшний хувьд *GRE*-ийн *quantitative reasoning*-тэй төстэй байна)
- Аналитик бичгийн ур чадварын шалгалт өгнө (яагаад энэ хөтөлбөрт орох хүсэлтэй байгаа 500 үгтэй эссе)
- Танилцуулах захидал-2ш (өмнөх сургуулийн багш нараас дор хаяж 1ш) бүрдүүлнэ.